

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 22

**ГУДАМЖНЫ ТОХИЖИЛТЫН АЖИЛ (Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо,
Өлзийтийн 1/1 дүгээр хэсгээс 2 дугаар хэсгийн МТ колонк хүртэлх 700м)-ЫН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: ХУДХААА/202001034

**Улаанбаатар хот
2020 он**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 22

Тендер шалгаруулалтын нэр: ГУДАМЖНЫ ТОХИЖИЛТЫН АЖИЛ (Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийтийн 1/1 дүгээр хэсгээс 2 дугаар хэсгийн МТ колонк хүртэлх 700м) Тендер шалгаруулалтын дугаар: ХУДХААА/202001034

Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос “ГУДАМЖНЫ ТОХИЖИЛТЫН АЖИЛ (Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийтийн 1/1 дүгээр хэсгээс 2 дугаар хэсгийн МТ колонк хүртэлх 700м)”-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын (www.tender.gov.mn) дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:
 - Сүүлийн **2** жилд /2018, 2019 он/ гүйцэтгэсэн борлуулалтын орлогын дундаж нь 20 000 000 /*хорин сая*/ төгрөгөөс багагүй байна.
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:
 - 2018, 2019 он сүүлийн 2 жилийн аль нэг жилийн хугацаанд дор хаяж нэг удаа **15 000 000** /*арван таван сая*/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр орсон байна.
- Тухайн ажилд шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байх. **Тийм**
Үүнд:
 - *Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:*
 - **2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт /ба түүнээс дээш/**

Үнийн саналыг **2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10.00 минут**-аас өмнө өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10.30 минут** -т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй**.

Давуу эрхийн зөрүү **тооцно**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээс үнэ төлбөргүй татаж авна уу.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө,
Иргэдэд үйлчлэх төв байр, 9 давхарт 902 тоот, утас: 11-70009011

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хоригласан мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгаар баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (1) Үнийн санал /маягтын дагуу албан бланк дээр бэлтгэсэн байх/;
 - (2) а. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
б. Үе шатны ажлын хуваарь ;
 - (3) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (4) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ -1.1 (а)	Захиалагч нь: <i>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар</i>
ТӨӨЗ -1.1 (б)	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь ГУДАМЖНЫ ТОХИЖИЛТЫН АЖИЛ (Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийтийн 1/1 дүгээр хэсгээс 2 дугаар хэсгийн МТ колонк хүртэлх 700м) Дугаар: ХУДХААА/202001034
ТӨӨЗ -1.1 (в)	Тендерт оролцогч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. <i>/албан бланкан дээр баталгаажуулж ирүүлнэ/</i>
ТӨӨЗ -1.1 (г)	Тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийн баталгааг бичгээр гаргах, түүний итгэмжлэл <i>/МАЯГТ № ТШМ 2-3-ын дагуу албан бланкан дээр баталгаажуулж ирүүлнэ/</i>
ТӨӨЗ -1.1 (д)	Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар ирүүлнэ. <i>/ мөн түншилэлийн гишүүнд хамаарна /</i>
ТӨӨЗ -1.1 (е)	Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх: - Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт - Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендерт оролцогч татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй ба www.tender.gov.mn сайтаас нээлт болсон өдрөөр татварын тодорхойлолтыг захиалагч татан авч үзнэ. - Харьяа Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт - Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тухай харилцагч банкны тодорхойлолт Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна. Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно.
ТӨӨЗ -3.1.2 (а)	1. Үе шатны ажлын хуваарь /гарын үсэг зурж баталгаажуулах/ МАЯГТ № ТШМ 2-1-ын дагуу ирүүлэх 2. Тендерт оролцогч нь санал болгосон үнийн дүнд багтаан тухайн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. 3. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.
ТӨӨЗ -3.1.2 (б)	Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь: Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна /төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181-р тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрэм, БХБ-ын сайдын 2015 оны 185-р тушаалаар батлагдсан барилгын норм ба дүрэм шинэчлэн батласаны дагуу тооцож Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар хийж гүйцэтгэнэ/. Хөнгөлөлт тооцсон тохиолдолд задаргаа болон үндэслэлийг ирүүлнэ.
ТӨӨЗ -3.1.3 (а)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй. www.tender.gov.mn сайтаас шаардлагатай мэдээллийг авна.

<p>ТООЗ -3.1.3 (б)</p>	<p>Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: 2</p> <p><i>Сүүлийн 2 жил /2018, 2019 он/</i></p> <table border="1" data-bbox="512 300 1430 533"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөвт өртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дүн</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																	
1																					
2																					
	Дүн																				
<p>ТООЗ -3.1.3 (в)</p>	<p>Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он</i></p> <p>Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь: Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн борлуулалтын орлогын дундаж нь 20 000 000 төгрөгөөс багагүй байх.</p>																				
<p>ТООЗ -3.1.3 (г)</p>	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо:</p> <p><i>Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн аль нэг жилд ядаж нэг удаа 15 000 000 төгрөгөөс багагүй өртөгтэй ижил төстэй ажил үндсэн гүйцэтгэгчээр гүйцэтгэсэн байх, түүнийг нотлох баримт: Улсын комиссын акт, ажил гүйцэтгэх гэрээ, захиалагч байгууллагын тодорхойлолтын хамт хавсаргана.</i></p> <table border="1" data-bbox="512 960 1465 1193"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөвт өртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дүн</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																	
1																					
2																					
	Дүн																				
<p>ТООЗ -3.1.3 (д)</p>	<p>Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон инженер, техник, мэргэжилийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл.</p> <p>Дараах хүснэгтэнд үзүүлсэн удирдах болон инженер техникийн ажилтаныг ажиллуулна.</p> <table border="1" data-bbox="512 1391 1465 1742"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Ажилсан жилийн туршлага /мэргэжлээр э/</th> <th>Мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Барилгын инженер</td> <td>1</td> <td>2</td> <td>Барилгын инженер</td> </tr> <tr> <td>2</td> <td>Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</td> <td>1</td> <td>1</td> <td>Мэргэжил харгалзахгүй</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> - <i>Инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, иргэний үнэмлэхний хуулбар, мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</i> - <i>Барилгын инженер, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байна.</i> - <i>Нийгмийн даатгалын дэвтрийн даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, Нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</i> 	№	Албан тушаал	Хүний тоо	Ажилсан жилийн туршлага /мэргэжлээр э/	Мэргэжил	1	Барилгын инженер	1	2	Барилгын инженер	2	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1	Мэргэжил харгалзахгүй					
№	Албан тушаал	Хүний тоо	Ажилсан жилийн туршлага /мэргэжлээр э/	Мэргэжил																	
1	Барилгын инженер	1	2	Барилгын инженер																	
2	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1	Мэргэжил харгалзахгүй																	

	<ul style="list-style-type: none"> - <i>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь ХАБЭА-н сургалтанд хамрагдсаныг нотолж гэрчилгээний /сертификат/ хуулбарыг ирүүлнэ</i> - <i>Тендерт оролцогч нь ХУД-т хөрөнгө оруулалтын өөр ажил гүйцэтгэж байгаа болон өөр тендер шалгаруулалтанд оролцож байгаа бол зөвхөн тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудыг танилцуулах бөгөөд давхцсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</i> 									
ТООЗ -3.1.3 (е)	<p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th>№</th> <th>Тоног төхөөрөмжийн нэр</th> <th>Тоо ширхэг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ачааны машин /1.5 тонноос дээш/</td> <td>1</td> </tr> <tr> <td>2</td> <td>бульдозер</td> <td>1</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> - <i>Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх</i> - <i>Машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтыг МАЯГТ №ТШМ-2 1.4-т заасны дагуу бөглөж техникийн гэрчилгээний хуулбарыг хавсаргаж ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол эзэмшигчтэй нь гэрээ хийж машин механизмын гэрчилгээний хуулбарыг хавсаргана. / хуулбар нь тод гаргацтай байна/</i> 	№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	1	Ачааны машин /1.5 тонноос дээш/	1	2	бульдозер	1
№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг								
1	Ачааны машин /1.5 тонноос дээш/	1								
2	бульдозер	1								
ТООЗ -3.1.3 (ж)	<p>Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь хүртэл хувь байна.</p> <ul style="list-style-type: none"> - Туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг эх хувиар ирүүлнэ. - Гэрээнд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын талаар болон төсөвт өртгийг тодорхой тусгасан байна. <p>Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба ТООЗ-нд дурдсан бусад шалгуурыг хангасан байх шаардлагатай.</p>									
ТООЗ -3.1.3 (з)	<p>Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Түншлэлийн хувьд чадварын доод шалгуур буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр ТООЗ 3.1.3/в/ ба /г/-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.</i> - <i>Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх/</i> - <i>Тусгай зөвшөөрөл /нотариатаар баталгаажуулсан байх/</i> - <i>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлийг хангасан тухай материалыг ирүүлэх.</i> 									
ТООЗ -3.1.4	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай <i>/нотариатаар баталгаажуулсан байх/</i>. Үүнд:</p> <p>Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:</p> <p style="text-align: center;">Хуучин бол</p> <ul style="list-style-type: none"> - 2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт /ба түүнээс дээш/ <p style="text-align: center;">Шинэ бол</p> <ul style="list-style-type: none"> - БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил /ба түүнээс дээш/ 									
ТООЗ -2.1 (а)	<p>-“Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал , хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” / MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011, MNS 5140-3:2011/-ыг мөрдөж тендерийн баримт бичгийг боловсруулна.</p>									
ТООЗ 2.1 (б)	<p>Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: ирүүлэхгүй</p>									

	<p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>-Тендерт оролцогч тендерийн хуудас бүрийг дугаарлаж, гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулж ирүүлэх. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ форматад хөрвүүлэн, өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендерт оролцогчийн цахим системээр ирүүлж оролцсон ТООЗ болон ТШӨХ-д заасан тендерийн баримт бичгийг бэлтгэн ирүүлсэн тендерийн материал нь тендерт оролцогчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн нууц үгтэй улмаас нээгдэхгүй /Adobe PDF/ форматад хөрвүүлсэн файл уншигдахгүй /тод гаргацтай байна/ тохиолдолд үнэлгээнд харгалзан үзэхгүй татгалзах үндэслэл болно</p>
ТООЗ 2.1 (в)	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p>
ТООЗ 2.2	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Цаг: 14 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Иргэдэд үйлчлэх төв байр Худалдан авах ажиллагааны алба Давхар болон өрөөний дугаар: 9 давхар 902 тоот Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Цаг: 14 цаг 30 минут</p>
ТООЗ 2.3	<p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хоригласан мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
ТООЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>
ТООЗ 7.2	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү: <i>тооцно</i></p> <p><i>ТБОНӨХБАУХАТХ-н 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4-т заасан давуу эрх.</i></p> <p>- <i>Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлт ирүүлнэ. Албан хүсэлтэд: Уг ажилд ашиглах бараа материалын нэрсийн жагсаалт, тоо ширхэг, нэг бүрийн үнэ, нийт үнэ, ажиллах хүчийг тусгаж өгнө.</i></p> <p>- <i>Нотлох баримтад: Тухайн бараа материалын тохирлын гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх/, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ /эх хувиар/-г ирүүлнэ.</i></p> <p>- <i>Дотоодын давуу эрх тооцуулахаар санал болгож буй иргэд нь тухайн орон нутгийн харъяат иргэд байна. Тэдний иргэний үнэмлэхний хуулбар, ажилд</i></p>

орохыг хүссэн өргөдөл, мэргэжлийн болон диплом, үнэмлэхийн эх хувиас хийсэн хуулбар, оршин суугаа багийн Засаг даргын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээ эсвэл хөлсөөр ажиллах гэрээ, ажилд томилсон тушаал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээ зэрэг бичиг баримтыг шаардсаны дагуу тендерт ирүүлнэ.

- Давуу эрхийг тооцохдоо “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2019 оны Давуу эрх тооцох аргачлалыг тус тус баримтлана.

Жич: Тендерт оролцогч албан хүсэлт, нотлох баримт ирүүлээгүй бол давуу эрх тооцохгүй.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



"ЗЭНДМЭНЭТУЛГА" ХХК
Барилгын зураг төсөл



"ӨСӨН ҮРЖИХ КОНСТРАКШИН" ХХК
Барилгын зураг төсөл

БАТЛАВ:
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Б. ЭНХБОЛД

УЛААНБААТАР ХОТ. ХАН-УУЛ ДҮҮРЭГ. 14-Р ХОРОО
ГУДАМЖНЫ ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЗУРАГ

Зургийн шифр: ӨҮК-02.04.20/03

ЗӨВШӨӨРСӨН.		БОЛОВСРУУЛСАН.		
Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Гүйцэтгэгч	
ЭДИЙН ЗАСАГ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА	Д.ОТГОНБАЯР		 Албан тушаал	Нэр
			"ӨҮК" ХХК-ийн захирал	А.Эрдэнэжүү
ЭДИЙН ЗАСАГ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН	О.МӨНГӨНШАГАЙ		 Албан тушаал	Нэр
			"Зэндмэнэтулга" ХХК-ийн захирал	Ц.Энхтуяа
			Захиалагч	
Албан тушаал	Нэр	Гарын үсэг		

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН



ТАЙЛБАР БИЧИГ

Зураг төсөл зохиох үндэслэл:

"Хан-Уул дүүргийн 14-р хороо, 1-р хэсэг, Өлзийтийн 1/1-ээс 2-р хэсгийн МТ колонк хүртэлх гудамжны тохижилтын зураг.

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолтой, Хан-Уул дүүргийн 14-р хороо, 1-р хэсэг, Өлзийтийн 1/1-ээс 2-р хэсгийн МТ колонк хүртэл 700 метр хэсгийн гудамжны тохижилтын ажлын зургийг "Ёсон Үржж Констракшин" ХХК-д 2020 оны 4 сард боловруулав.

Одоогийн байдал:

Хан-Уул дүүргийн 14-р хороо, Өлзийтийн 1/1-ээс 2-р хэсгийн 700 метр газар нь сул шароон хөрстэй, хуучин зам нь эвдэрч муудсан, уяр усанд идэгдэн эвдэрч муудсан, гэрэлтүүлэг болон хаягжилт байхгүй, хашаа жигд бус байна.

Өгөгдсөн талбайн хэмжээ: 700 метр үргэлжилсэн замын хойд талын хэсэг.

Зураг төсөл боловруулсан үе шат:

- 2020 оны 3 дугаар сарын 24-ны өдөр судалгаа, хэмжилтийн зурагийг хийв.
- 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр загвар зураг болон төсвийг боловруулж дуусав.

Архитектур төлөвлөлтийн шийдэл:



Хан-Уул дүүргийн 14-р хороо, Өлзийтийн 1/1-ээс 2-р хэсгийн 700 метр газар нь сул шароон хөрстэй, хуучин зам нь эвдэрч муудсан байгаа тул замыг сайжруулж нягтруулсан хөрс, хайрга дэйрга байхаар төлөвлөх. Яаган замын эргэлт, уулсварыг чанарын шарадлага хайгахаар төлөвлөх ба хөнгийн баршээтэй иргэдийн зорчин явах талбайг ямар нэг савдгүй байхаар төлөвлөнө. Замын ус зайлуулах налууг хашваны гадна талаар өлгөн хаяхаар төлөвлөж өгөх.

ОДООГИЙН БАЙДАЛ /ФОТО ЗУРАГ/



	Объект нэр:	УЛААНБААТАР ХОТ ХАМ-УУЛ ДҮҮРГ, 14-Р ХОРОО				
	Байрвал:	ГУДАМЖНЫ ТӨЛӨВӨЛТӨН				
	Зөвлөх:	А.Зарамжуу	Тайлбар бичиг			
	Архитектор:	Ц.Нямсүрэн	Урьт:	№ шат:	Хөдөл:	
Гүйцэтгэсэн:	М.Минорж	БГ шифр:	07/1-02.04.20/03	А3	01	03
Шалтгаан:	Ц.Нямсүрэн	ТГ шифр:	07/1-02.04.20/03	2020 он		

ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ М1:1000




	Цахилгааны шугам		Газрын өндөржилт		Төлөвлөж буй яаган хүний зам
	Газрын хаялбар		Төлөвлөж буй ус зайлуулах шуудуу		Төлөвлөж буй хөтөч хавтан
	Замын асгавас		Төлөвлөж буй ногоон зурвас		

ОДООГИЙН БАЙДАЛ /ФОТО ЗУРАГ/



ЗАМЫН ОГТЛОЛ



	Объект нэр:	УЛААНБААТАР ХОТ ХАМ-УУЛ ДҮҮРГ, 14-Р ХОРОО				
	Байрвал:	ГУДАМЖНЫ ТӨЛӨВӨЛТӨН				
	Зөвлөх:	А.Зарамжуу	Ерөнхий төлөвлөгөө			
	Архитектор:	Ц.Нямсүрэн	Урьт:	№ шат:	Хөдөл:	
Гүйцэтгэсэн:	М.Минорж	БГ шифр:	07/1-02.04.20/03	А3	03	03
Шалтгаан:	Ц.Нямсүрэн	ТГ шифр:	07/1-02.04.20/03	2020 он		

Тав. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

а/ ажлын төсөвт өртгийн товчоо

1. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ үнэлэгдэх ажлын тоо хэмжээний жагсаалт болон тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт зэргийг бодит байдалтай холбож нягтлан үзэхийг анхааруулж байна.
2. Гэрээнд тусгайлан заагаагүй нөхцөлд тендерт ирүүлсэн үнийн саналд ажлын тоо хэмжээнд тохирсон үнэд барилгын ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, ажиллах хүчний хөлс, материал, түүний элэгдэл засвар, нийгмийн ба эрүүл мэнд, үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн зардлууд, ашиг бүх төрлийн татвар хураамж, банкны үйлчилгээний шимтгэл, үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалттай бүх зардлууд мөн нэмэгдэл дайвар ба захиалагчийн техник хяналтын зардал, гэрээний үүрэгт хамруулах ёстой бусал үүрэг хариуцлагыг тооцож шингээсэн байна.
1. Тухайн ажилд шаардлагатай материалын нийлүүлэлтийн график, захиалгын гэрээний талаарх мэдээллийг ирүүлсэн байх.
2. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12–ын шинэчлэгдсэн программын дагуу үнэлж, үнэлгээнд техник хяналт, магадлашгүй ажил, НӨАТ, нормчлалын санг тооцож оруулна зэргийг төсөв зохиох зааврийн дагуу нэг бүрчлэн тооцож тусгана.
3. Ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг үнэлэхдээ ажил гүйцэтгэх технологийн дагуу ажил, ажилбаруудаар задалж нэгжийн норм үнэлгээгээр үнэлэхийг анхааруулж байна. Гэхдээ нэгжийн норм үнэлгээ дотроо тусгагдсан ажилбаруудыг дахин давтан үнэлсэн байж болохгүй.
4. Талбайгаас гарсан хог хаягдлыг Хан-Уул дүүргийн зөвшөөрөгдсөн хогийн цэгт тээвэрлэж зайлуулахаар зардлыг тооцож ирүүлнэ.

б/ ажлын төсөвт өртгийн товчоо

д/д	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
	Ажиллах хүчний зардал	
	Материал	
	Тээвэр	
	Машин ашиглалт	
	Шууд зардлын дүн:	
	Нэмэгдэл зардал 73.8%	
	Ашиг	
	Барилга угсралтын ажлын дүн	
	НӨАТ 10%	
	Норм нормативын сан	
	ДҮН	
	Захиалагчийн албаны зардал	
	Зохиогчийн хяналтын зардал	
	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	
	ДҮН	
	Магадлашгүй ажлын зардал	
	Бусад нэмэлт зардал	
	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ	

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Гудамж зам талбайг механизмаар тэгшлэх	м3	168
Модон хашааг тэгшилэж модны зарим хэсгийг солих шинэчлэх засварлах	1м	1000
Тэгшилж янзалсан хашааны дээгуур цэвэр банзан эмжээр хадах	м2	405
Модон гадаргууг фасадны модны зориулалттай эмульсэн будгаар будах	м2	1680
Айлуудын хашааны төмөр хаалгыг тосон будгаар будах	м2	268
Хашааны хаалганд номер хаяг тогтоох	иж бүрдэл	27

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

МАЯГТ № ТШМ 2-1

№	Ажлын нэр	Ажиллах хүч	Ажиллах хоног	Хугацаа /хоног/			
				Гэрээ хийсэн өдрөөс 1 хоног	2 хоног	3 хоног	4 хоног
1							
2							
3							
Нийт							

Тайлбар: Төсөлд тусгагдсан барилга угсралтын ажлыг үндсэн нэр төрлөөр гүйцэтгэх, зүгшрүүлэлт, туршилт тохируулга хийхкомисс ажиллуулан байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх зэрэг бүх ажлууд графикт тусгагдана.

Тэмдэг ГАРЫН ҮСЭГ _____
 ОВОГ НЭР _____
 КОМПАНИЙН НЭР _____

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]*, *[гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч _____
Компанийн _____ ажилтай _____ овогтой _____ нь _____ компанийн
нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул
_____ овогтой _____ ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

_____ овогтой _____ нь _____ компанийг төлөөлж _____
компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах,
гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад
холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 2017 оны __ дугаар сарын __ ны өдөр гарын үсэг
зурав.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____
Албан тушаал _____

Баталгаажуулагчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____
Албан тушаал _____

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :

- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ГУДАМЖНЫ ТОХИЖИЛТЫН АЖИЛ (Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийтийн 1/1 дүгээр хэсгээс 2 дугаар хэсгийн МТ колонк хүртэлх 700м)
ГЕН 2.1	Ажлын талбай нь: <i>Хан-Уул дүүрэгт 14 р хороо</i> байршина.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>Б.Энхболд /Засаг даргын Тамгын газрын дарга/</i>
ГЕН 3.1	Ажил эхлэх өдөр <i>Гэрээ байгуулсан өдрөөс</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>Гэрээ байгуулагдсанаас хойш 30 хоног</i> <i>Хэрэв гүйцэтгэгч нь тус ажлыг хугацаанд нь дуусгаж чадаагүй тохиолдолд гэрээнд заагдсаны дагуу алданги ноогдуулна.</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаа нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,05 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
	Шилэн дансны тухай хуулийн дагуу https://www.shilendans.gov.mn/ -сайтад бүртгэлтэй байх, “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл (Улирал бүр)” хэсэгт хүлээн авсан санхүүжилтаа мэдээлсэн байх